

**МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2009 ОНЫ
1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ
2009 ОН**

**ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2009 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

2009 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, даатгалын зуучлагч 4 компани болон даатгалын төлөөлөгч 1163 иргэн даатгалын зах зээлд оролцсон байна.

I. ХӨРӨНГӨ

Энэ оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй дээрх 16 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 34,9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,6 тэрбум төгрөг буюу 15,1 хувиар, оны эцсээс 0,6 тэрбум төгрөгөөр буюу 1,7 хувиар өссөн байна.

2008 оны 1 дүгээр улиралд системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 26.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86,5 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 4.1 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 13,5 хувийг эзэлж байсан бол 2009 оны 1 дүгээр улиралд эргэлтийн хөрөнгө 30.3 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 86.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0,3 пунктээр өссөнөөс харахад тайлант хугацаанд хөрөнгийн бүтцэд онцын өөрчлөлт гараагүй байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

(сая төг)

| Үзүүлэлтүүд | 2008-I | | 2009-I | | өсөлт/бууралт | |
|-----------------------|-----------------|--------------|-----------------|--------------|----------------|--------------|
| | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь |
| Эргэлтийн хөрөнгө | 26 224,2 | 86,5 | 30 289,4 | 86,8 | 4 065,2 | 115,5 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 4 093,6 | 13,5 | 4 614,5 | 13,2 | 520,9 | 112,7 |
| Нийт хөрөнгө | 30 317,8 | 100,0 | 34 903,9 | 100,0 | 4 586,1 | 115,1 |

2009 оны 1 дүгээр улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 71,6 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 12,4 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 7.7 хувийг дансны авлага, үлдэх 18,4 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 10,5 пунктээр өссөн бол богино хугацаат хөрөнгө оруулалт 5,1 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 4,8 пунктээр тус тус буурч, дансны авлагын нийт эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ хэвээр хадгалагдсан байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс нилээд хэдэн пунктээр өссөн гол шалтгаан нь өнгөрөгч 2008 оны 3 дугаар улирлаас эхлэн Хорооны 2006 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмын дагуу даатгалын компаниудын санхүүгийн байдлыг шалгаж эхэлсэнтэй холбоотой байна (Хүснэгт-2).

Эргэлтийн хөрөнгө

(сая төг)

| Үзүүлэлтүүд | 2008-I | | 2009-I | | өсөлт/бууралт | |
|-----------------------------------|-----------------|--------------|-----------------|--------------|----------------|--------------|
| | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 16 010.5 | 61.1 | 21 675.9 | 71.6 | 5 665.4 | 135.4 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 4 601.6 | 17.5 | 3 749.3 | 12.4 | - 852.3 | 81.5 |
| Дансны авлага | 2 162.0 | 8.2 | 2 325.1 | 7.7 | 163.1 | 107.5 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 3 450.3 | 13.2 | 2 539.1 | 8.4 | - 911.2 | 73.6 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 26 224.4 | 100.0 | 30 289.4 | 100.0 | 4 065.0 | 115.5 |

Энэ оны 3 дугаар сарын 31-ний байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 12.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт даатгалын зах зээл дээрх хөрөнгийн 35,3 хувийг эзэлж байгаа бол “Нийслэл даатгал” ХХК хамгийн бага буюу 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 1.8 хувийг эзэлж байна (Хүснэгт-3). Өнгөрсөн оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Прайм женерал даатгал” ХХК 1,8 тэрбумийн хөрөнгөтэйгээр 5 дугаарт орж байсан бол энэ онд 2,6 тэрбум төгрөгийг хөрөнгөөр 3 дугаарт жагсах болсон байна.

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 51,9 хувийг “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Прайм женерал даатгал” ХХК гэсэн 3 даатгалын компанийн хөрөнгө бүрдүүлж байна.

Нийт хөрөнгийн хэмжээ


| № | Компанийн нэр | Нийт хөрөнгө (сая төг) | Эзлэх хувь |
|----|---------------------------------|---------------------------|---------------|
| 1 | Монгол даатгал | 12 331.4 | 35.3 |
| 2 | Бодь даатгал | 3 213.0 | 9.2 |
| 3 | Прайм женерал даатгал | 2 569.8 | 7.4 |
| 4 | Миг даатгал | 2 075.2 | 5.9 |
| 5 | Ард даатгал | 1 841.1 | 5.3 |
| 6 | Номин даатгал | 1 833.2 | 5.3 |
| 7 | Практикал даатгал | 1 554.6 | 4.5 |
| 8 | Түшиг даатгал | 1 488.9 | 4.3 |
| 9 | Улаанбаатар хотын даатгал | 1 390.5 | 4.0 |
| 10 | Монгол траст холдинг даатгал | 1 165.9 | 3.3 |
| 11 | Нэйшнл лайф даатгал | 1 148.3 | 3.3 |
| 12 | УБ даатгал | 1 145.9 | 3.3 |
| 13 | Ган зам даатгал | 901.9 | 2.6 |
| 14 | Мөнх даатгал | 900.2 | 2.6 |

| | | | |
|----|-----------------|-----------------|--------------|
| 15 | Жонон даатгал | 709.6 | 2.0 |
| 16 | Нийслэл даатгал | 634.2 | 1.8 |
| | ДҮН | 34 903.7 | 100.0 |

II. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2009 оны 1 дүгээр улиралд нөөц сангийн хэмжээ 15,0 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,1 тэрбум төгрөгөөр буюу 21,5 хувиар буурсан мэт харагдаж байгаа боловч нөөц сангийн бодит бууралт биш бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ын хавсралтын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэх болсонтой холбоотой байна (Зураг-1).

Зураг-1



Тайлант хугацаанд даатгалын салбарын хэмжээгээр 958,6 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бол өнгөрсөн онд 75,1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан байна.

III. ОРЛОГО, ЗАРДАЛ

Тайлант хугацаанд даатгалын салбар 4,0 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 0,8 тэрбум төгрөг буюу 20,0 хувийг давхар даатгалын хураамжид, 0.04 тэрбум

төгрөг буюу 1,0 хувийг буцаасан даатгалын хураамжид олгож 3,2 тэрбум төгрөгийн тайлант хугацааны даатгалын цэвэр хураамжийн орлого олжээ.

Энэ оны эхний улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын нийт хураамжийн орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38,1 хувиар буюу 2,5 тэрбум төгрөгөөр буурсан нь “МИАТ” ХК-ийн агаарын хөлөг, хариуцлагын даатгалын хураамжийн орлого энэ онд жилийн туршид хуваагдаж орж ирэх болсонтой холбоотой байна.

Орлогод тооцсон хураамжийн 16,8 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан бүрдүүлэхэд, 26,2 хувийг нөхөн төлбөр олгоход зориулсан байна.

2008 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар даатгалын салбар 521,7 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол энэ оны эхний улирлын байдлаар 1,5 тэрбум төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажилласан нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 3 дахин өссөн байна. Татвар төлөхийн өмнөх ашгийн хэмжээ ийнхүү огцом өссөн нь өмнөх оны мөн үед алдагдалтай ажиллаж байсан “Монгол даатгал”, “Түшиг даатгал”, “Мөнх даатгал” ХХК-иуд энэ оны эхний улиралд ашигтай ажилласан, “Бодь даатгал”, “Ард даатгал”, “Практикал даатгал” ХХК-иудын ашиг үлэмж хэмжээ (2,3-22,3 дахин)-гээр өссөнтэй холбоотой байна.

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийг 2009 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 1,7 тэрбум төгрөг буюу нийт зах зээлийн 41.9 хувийг эзэлж хамгийн өндөр орлого олсон бол “Монгол траст холдинг даатгал” ХХК хураамжийн орлогогүйгээр жагсаалтын хамгийн сүүлд жагссан байна (Хүснэгт-4). Даатгалын зах зээл дэх нийт хураамжийн орлогын 54,5 хувийг “Монгол даатгал”, “Прайм генерал даатгал” ХХК гэсэн 2 даатгалын компанийн олсон хураамжийн орлого бүрдүүлж байна.

Хүснэгт-4

Даатгалын хураамжийн орлого


| № | Компанийн нэр | Хураамжийн орлого (сая.төг) | Эзлэх хувь |
|----|---------------------------|-----------------------------|------------|
| 1 | Монгол даатгал | 1 690.4 | 41.9 |
| 2 | Прайм генерал даатгал | 511.8 | 12.7 |
| 3 | Бодь даатгал | 456.9 | 11.3 |
| 4 | Миг даатгал | 426.1 | 10.6 |
| 5 | Улаанбаатар хотын даатгал | 240.1 | 5.9 |
| 6 | Номин даатгал | 216.7 | 5.4 |
| 7 | Түшиг даатгал | 161.0 | 4.0 |
| 8 | Ард даатгал | 156.3 | 3.9 |
| 9 | Практикал даатгал | 60.1 | 1.5 |
| 10 | Мөнх даатгал | 35.0 | 0.9 |
| 11 | УБ даатгал | 29.7 | 0.7 |
| 12 | Ган зам даатгал | 25.3 | 0.6 |
| 13 | Нийслэл даатгал | 16.8 | 0.4 |

| | | | |
|----|------------------------------|----------------|--------------|
| 14 | Нэйшнл лайф даатгал | 7.9 | 0.2 |
| 15 | Жонон даатгал | 3.6 | 0.1 |
| 16 | Монгол траст холдинг даатгал | | 0.0 |
| | ДҮН | 4 037.7 | 100.0 |

IV. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ОЛГОВОР

2009 оны 1 дүгээр улиралд нийт 3,9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 71,0 хувь буюу 2,7 тэрбум төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 12,6 хувь буюу 485,4 сая төгрөг нь хариуцлагын даатгалын, 9,9 хувь буюу 381,9 сая төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын, 6,6 хувь буюу 253,2 сая төгрөг нь санхүүгийн даатгалын хураамжаас орсон орлого байна (Зураг-2). Санхүүгийн даатгалын хэлбэр 2007 оноос шинээр бий болж зах зээлд нэвтэрснээр энэ хэлбэрийн даатгалын хураамжийн орлого нийт хураамжийн орлогод тодорхой хувь эзлээд зогсохгүй жил ирэх тусам өсч байна. Түүнчлэн энэ оны эхний улиралд эд хөрөнгийн даатгалын хураамжийн орлогын нийт хураамжийн орлогод эзлэх хувь хэмжээ 13,0 пунктээр өссөн нь өнгөрсөн оны мөн үед бүтнээрээ орж ирж байсан давхар даатгалын хураамжийн орлого орж ирээгүй байгаатахолбоотой байна.

Зураг-2



2009 оны 1 дүгээр улирлын даатгалын хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын нийт хураамжийн орлого 2,6 тэрбум төгрөгөөр буюу 40,7 хувиар буурсан байна. Энэхүү өсөлтийг даатгалын ангиллаар нь задлан харвал амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 18,7 хувиар буюу 88,1 сая төгрөгөөр, эд хөрөнгийн даатгал

27,5 хувиар буюу 1,0 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 77,7 хувиар буюу 1,7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол санхүүгийн даатгалын хураамж 2,7 дахин буюу 160,5 сая төгрөгөөр өссөн байна (Хүснэгт-5). Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд нийт хураамжийн орлогын бууралтанд хариуцлагын даатгалын бууралт 63,6 хувийн хүчтэй нөлөөлснийг доорх хүснэгтээс харж болохоор байна.

Хүснэгт-5


Даатгалын хураамжийн орлого

(сая төг)

| Даатгалын ангилал | 2008-I | 2009-I | Өсөлт/бууралт | | Өсөлтийн хувь |
|---|----------------|----------------|------------------|-------------|---------------|
| | | | тоо | хувь | |
| Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал | 470.0 | 381.9 | - 88.1 | 81.3 | 3.3 |
| Эд хөрөнгийн даатгал | 3 779.4 | 2 740.7 | - 1 038.7 | 72.5 | 39.1 |
| Хариуцлагын даатгал | 2 173.1 | 485.4 | - 1 687.7 | 22.3 | 63.6 |
| Санхүүгийн даатгал | 92.7 | 253.2 | 160.5 | 273.1 | -6.0 |
| Дүн | 6 515.2 | 3 861.2 | - 2 654.0 | 59.3 | 100.0 |

2009 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 1,2 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосны 66,2 хувь буюу 801,1 сая төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 13,5 хувь буюу 163,5 сая төгрөг нь хариуцлагын даатгалын, 11,0 хувь буюу 133,0 сая төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын, 9,3 хувь буюу 112,5 сая төгрөг нь санхүүгийн даатгалын нөхөн төлбөр байна (Зураг-3). Санхүүгийн даатгалын хэлбэр 2007 оноос шинээр бий болж зах зээлд нэвтэрсэн ч энэ хэлбэрийн даатгалын хураамжийн орлого нийт хураамжийн орлогод тодорхой хувь эзлээд зогсохгүй жил ирэх тусам өсч байгаатэй уялдан нөхөн төлбөр нь ч өссөнийг харж болохоор байна.

(Зураг-3)



Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар олгосон нөхөн олговрын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт нөхөн олговрын хэмжээ 19,6 хувиар буюу 197,9 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг даатгалын ангилалаар нь авч үзвэл амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын нөхөн олговор 97,9 хувиар буюу 65,8 сая төгрөгөөр, эд хөрөнгийн даатгал 13,9 хувиар буюу 97,8 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 2,5 дахин буюу 68,2 сая төгрөгөөр тус тус өссөн бол хариуцлагын даатгал 17,2 хувиар буюу 33,9 сая төгрөгөөр буурсан байна (Хүснэгт-6). Санхүүгийн даатгалын нөхөн олговрын энэхүү огцом өсөлт нь “Монгол даатгал” ХХК-ийн зээлийн эрсдэлийн болон бизнес тасалдлын даатгалд олгосон нөхөн олговор 2,9 дахин буюу 72,9 сая төгрөгөөр өссөнөөр тайлбарлагдаж байна.

Хүснэгт-6

Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

(сая төг)

| Даатгалын ангилал | 2008-I | 2009-I | Өсөлт/бууралт | | Өсөлтийн хувь |
|---|----------------|----------------|---------------|--------------|---------------|
| | | | тоо | хувь | |
| Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал | 67.2 | 133.0 | 65.8 | 197.9 | 33.2 |
| Эд хөрөнгийн даатгал | 703.3 | 801.1 | 97.8 | 113.9 | 49.4 |
| Хариуцлагын даатгал | 197.4 | 163.5 | - 33.9 | 82.8 | -17.1 |
| Санхүүгийн даатгал | 44.3 | 112.5 | 68.2 | 254.0 | 34.5 |
| Дүн | 1 012.2 | 1 210.1 | 197.9 | 119.6 | 100.0 |

V. НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Тайлант хугацаанд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 28,6 хувь болж 2008 оны мөн үеэс 2,2 пунктээр буурсан байна (Зураг-4).

Зураг-4



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2009 оны 1 байдлаар “Номин даатгал” ХХК хамгийн өндөр буюу 49.5 хувьтай байсан бол “Жонон даатгал” ХХК 0,0 хувьтай байсан байна (Хүснэгт-7).

Хүснэгт - 7

Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

| № | Даатгалын компаниудын нэрс | Хохирол нөхөлтийн түвшин (хувиар) | | Өсөлт/бууралт, (пунктээр) |
|----|------------------------------|-----------------------------------|-------------|---------------------------|
| | | 2008-I | 2009-I | |
| 1 | Номин даатгал | 71.2 | 49.5 | -21.7 |
| 2 | Түшиг даатгал | 28.9 | 47.1 | 18.2 |
| 3 | Ард даатгал | 35.5 | 45.5 | 10.0 |
| 4 | Монгол даатгал | 39.8 | 32.7 | -7.1 |
| 5 | Миг даатгал | 8.9 | 30.3 | 21.4 |
| 6 | Мөнх даатгал | 49.4 | 29.8 | -19.6 |
| 7 | Прайм женерал даатгал | 14.6 | 20.7 | 6.1 |
| 8 | Бодь даатгал | 26.3 | 17.4 | -8.9 |
| 9 | Нийслэл даатгал | 27.3 | 17.3 | -10.0 |
| 10 | УБ даатгал | 17.8 | 16.1 | -1.7 |
| 11 | Улаанбаатар хотын даатгал | 21.3 | 6.1 | -15.2 |
| 12 | Практикал даатгал | 18.0 | 5.2 | -12.8 |
| 13 | Ган зам даатгал | 13.8 | 1.7 | -12.1 |
| 14 | Монгол траст холдинг даатгал | 0.0 | 0.4 | 0.4 |
| 15 | Жонон даатгал | 15.0 | 0.0 | -15.0 |
| | ДҮН | 30.8 | 28.6 | -2.2 |

Даатгалын компаниудын 2009 оны 1 дүгээр улиралд олгосон хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Түшиг даатгал”, “Ард даатгал”, “Миг даатгал”, “Прайм женерал даатгал”, “Монгол траст холдинг даатгал” ХХК-иудын хохирол нөхөлтийн түвшин өсч харин бусад компаниудынх буурсан байна.

VI. ДАВХАР ДААТГАЛ

2008 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй 6 компани давхар даатгуулж 800,3 сая төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 1,6 тэрбум төгрөгөөр буюу 66,0 хувиар, энэ оны эхний байдалтай харьцуулахад 3,9 тэрбум төгрөгөөр буюу 83,1 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд нийт давхар даатгалын хураамж ингэж огцом унасан гол хүчин зүйл нь “МИАТ” ХХК-ийн иргэний агаарын хөлгийн даатгалын хураамж өмнөх онд жилийн эхэнд бүтнээр төлөгддөг байсан бол энэ онд жилийн турш хувааж төлөх болсонтой холбоотой байна (Хүснэгт-8).

Давхар даатгалын хураамж

(сая төг)

| № | Компанийн нэр | 2008-I | | 2009-I | | Өсөлт/бууралт | |
|---|-----------------------|----------------|--------------|--------------|--------------|------------------|-------------|
| | | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь |
| 1 | Ард даатгал | | 0.0 | 50.0 | 6.2 | 50.0 | |
| 2 | Бодь даатгал | 2 169.4 | 92.1 | 91.4 | 11.4 | - 2 078.0 | 4.2 |
| 3 | Прайм женерал даатгал | 59.1 | 2.5 | 143.3 | 17.9 | 84.2 | 2.4 дахин |
| 4 | Практикал даатгал | | 0.0 | | 0.0 | 0.0 | |
| 5 | Миг даатгал | 58.8 | 2.5 | 251.0 | 31.4 | 192.2 | 4.3 дахин |
| 6 | Монгол даатгал | 56.9 | 2.4 | 260.9 | 32.6 | 204.0 | 4.6 дахин |
| 7 | Номин даатгал | 10.7 | 0.5 | 3.7 | 0.5 | - 7.0 | 34.6 |
| 8 | Түшиг даатгал | | 0.0 | | 0.0 | 0.0 | |
| | ДҮН | 2 354.9 | 100.0 | 800.3 | 100.0 | - 1 554.6 | 34.0 |

2008 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад энэ оны 1 дүгээр улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК-ийн төлсөн давхар даатгалын хураамж хамгийн өндөр хувиар буюу 4,6 дахин өссөн нь энэ оноос “Дунгхүн констракшн” ХХК-тай байшин барилгын давхар даатгал (260,9 сая төгрөгийн давхар даатгалын хураамж)-ын үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой байна. Харин энэ оны эхний улирлын байдлаар “Бодь даатгал” ХХК-ийн давхар даатгалын хураамжийн орлого 95,8 хувиар буюу 2,1 тэрбум төгрөгөөр буурсан нь “МИАТ” ХХК-ийн иргэний агаарын хөлгийн даатгалыг 2009 оноос хийхгүй болсон шалтгаантай байгаа бол энэхүү даатгалын хэлбэрийг “Миг даатгал” ХХК хийхээр болсон учраас тайлант хугацаанд давхар даатгалын хураамж нь 4,3 дахин өссөн байна.

VII. ДҮГНЭЛТ

2007 оны 1 дүгээр улирлаас 2008 оны 1 дүгээр улирлын хооронд 73,7 хувиар өсч байсан даатгалын нийт хураамжийн орлого 2009 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэсээ 40,7 хувиар буурсан байна. Энэхүү бууралтын дийлэнх нь өмнөх оны 1 дүгээр улиралд бүрэн төлөгдөж байсан давхар даатгалын хураамжийн орлого энэ жил, жилийн турш хуваагдаж орж ирэхээр болсонтой холбоотой хэдий ч бусад хүчин зүйл тухайлбал дэлхийн эдийн засгийн хямрал бага зэрэг нөлөөлсөн гэж хэлж болохоор байна.

Даатгалын салбарын бусад гол үзүүлэлтүүд нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад буураагүй боловч өсөлтийн хурд удааширсан байна. Тухайлбал нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны 1 дүгээр улиралд 38,9 хувиар өсч байсан бол тайлант хугацаанд 15,1 хувиар, эргэлтийн хөрөнгө 40,5 хувиар өсч байсан бол тайлант хугацаанд 15,5 хувиар, эргэлтийн бус хөрөнгө 29,4 хувиар өсч байсан бол 12,7 хувиар өссөн байна.

Хэдийгээр даатгалын салбарын гол үзүүлэлтүүд суларч эхэлсэн ч салбарын хуримтлагдсан алдагдлын хувьд өнгөрсөн оны 1 дүгээр улиралд 75,1 сая төгрөгт хүрч байсан бол энэ оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 958,6 сая төгрөгийн ашигтай, өмнөх оны мөн үед 521,7 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан бол энэ оны эхний улирлын байдлаар 1,4 тэрбум төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллаж чадсан байна.